210104	Урамшуулал	17,654,500.00	17,653,443.54	1,056.46	99.99
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,387,000.00	22,876,789.70	4,510,210.30	83.53
210201	Тэтгэврийн даатгал	18,623,400.00	15,568,696.22	3,054,703.78	83.60
210202	Тэтгэмжийн даатгал	2,190,900.00	2,000,937.41	189,962.59	91.33
210203	ҮОМШӨ ний даатгал	1,752,700.00	1,465,323.20	287,376.80	83.60
210204	Ажилгүйдлийн даатгал	438,200.00	386,647.76	51,552.24	88.24
210205	Эрүүл мэндийн даатгал	4,381,800.00	3,455,185.11	926,614.89	78.85
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	8,174,200.00	8,174,200.00	-	100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,174,200.00	8,174,200.00	-	100.00
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,180,700.00	15,180,700.00	(0.00)	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	15,180,700.00	15,180,700.00	(0.00)	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	15,180,700.00	15,180,700.00	(0.00)	100.00
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	9,786,200.00	8,376,000.00	1,410,200.00	85.59
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	9,786,200.00	8,376,000.00	1,410,200.00	85.59
210	Бараа, үйлчилгээний зардал	9,786,200.00	8,376,000.00	1,410,200.00	85.59
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,219,200.00	1,219,200.00	-	100.00
210101	Үндсэн цалин	1,219,200.00	1,219,200.00	-	100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	152,400.00	152,400.00	-	100.00
210201	Тэтгэврийн даатгал	103,600.00	103,600.00	-	100.00
210202	Тэтгэмжийн даатгал	12,200.00	12,200.00	-	100.00
210203	ҮОМШӨ ний даатгал	9,800.00	9,800.00	-	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,400.00	2,400.00	-	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	24,400.00	24,400.00	-	100.00
2105	Нормативт зардал	1,328,400.00	1,328,400.00	-	100.00
210502	Хоол, хүнс	1,328,400.00	1,328,400.00	-	100.00
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	7,086,200.00	5,676,000.00	1,410,200.00	80.10
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,086,200.00	5,676,000.00	1,410,200.00	80.10
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,368,100.00	6,368,100.00	-	100.00
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	6,368,100.00	6,368,100.00	-	100.00
210	Бараа, үйлчилгээний зардал	6,368,100.00	6,368,100.00	-	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	6,368,100.00	6,368,100.00	-	100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,	6,368,100.00	6,368,100.00	-	100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,950,230,700.00	2,101,160,421.00	(150,929,721.00)	107.74
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,736,296,800.00	1,888,423,600.00	(152,126,800.00)	108.76
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,736,296,800.00	1,888,423,600.00	(152,126,800.00)	108.76
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	197,779,600.00	196,114,573.00	1,665,027.00	99.16
132001	Орон нутгийн төсвөөс	197,779,600.00	196,114,573.00	1,665,027.00	99.16
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	16,154,300.00	15,622,248.00	532,052.00	96.71
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,368,100.00	6,368,100.00	-	100.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,786,200.00	9,254,148.00	532,052.00	94.56
122	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	-	1,000,000.00	(1,000,000.00)	-
122001	Хандив тусламж /дотоод/	-	1,000,000.00	(1,000,000.00)	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	66,730,751.07	(66,730,751.07)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	194,380,746.77	(194,380,746.77)	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	67.00	67.00	-	100.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	43.00	43.00	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан	23.00	23.00	-	100.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	67.00	67.00	-	100.00
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч /ТҮБД/	43.00	43.00	-	100.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч /ТҮ/	24.00	24.00	-	100.00

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Баянчандмань сумын Ерөнхий боловсролын сургууль нь хамтын оролцоо үнэлгээний үр дүнд суурилан сургуулийн менежментийг сайжруулж, боловсролын үйлчилгээний чанарт ахиц гаргаж, хүүхэд бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломжийг бүрдүүлэх чиглэлээр сургалтын үйл ажиллагааг явуулахад оршино. Тус байгууллага нь Боловсрол шинжлэх ухааны яамны харьяа байгууллага юм.

Төв аймгийн Баянчандмань сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2023 оныг "Сургуулийн менежментийг сайжруулах" жил болгон зарлаж, дэвшүүлсэн зорилго, зорилтын хүрээнд байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 1 зорилт, 12 арга хэмжээтэйгээр боловсруулан хэрэгжүүлж, төлөвлөгөөг 100 хувиар биелүүлж ажилласан байна.

Төв аймгийн Баянчандмань сумын Ерөнхий боловсролын сургууль нь 75 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь үйл ажиллагаандаа

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- Боловсролын тухай хууль,
- Төсвийн тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил гүйлгээ худалдан авах тухай хууль,
- Шилэн дансны тухай хууль,
- Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжууд, мөн Сангийн яам болон харьяа эрүүл мэндийн яамнаас гаргасан тушаал, заавар журам шийдвэрүүдийг мөрдөж ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт *ороогүй* байна.

Төв аймгийн Баянчандмань сумын Ерөнхий боловсролын сургууль нь Боловсролын тухай хуулийг хэрэгжүүлэн хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, насан туршдаа суралцаж, ажиллах, ёс суртахуунтай, сайн зан чанартай иргэнийг төлөвшүүлэх үйл ажиллагаа явуулж, үйл ажиллагаандаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Боловсролын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжууд, мөн Сангийн яам болон харьяа яамнаас гаргасан тушаал, заавар журам шийдвэрүүдийг мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт *ороогүй* байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

2023 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр аймгийн Засаг даргын нэрэмжит үзлэг шалгалт хамрагдсан. Шалгалтаар 88,1 хувьтай үнэлэгдсэн.

2023 оны 11 дүгээр сарын 01-ны өдөр сумын хяналт шалгалт үнэлгээний хорооны шалгалтаар 87,0 хувьтай үнэлэгдсэн.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Баянчандмань сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Баянчандмань сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 281,209,2 мянган төгрөгөөр буюу 8.4 хувиар өссөн байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
<b>Мөнгөн хөрөнгө</b>	66,730.7	194,380.7	127,649.9
<b>Авлага</b>	31,001.8	31,144.1	142,366.1
<b>Бусад хангамжийн материал</b>	-	-	-
<b>Бараа материал</b>	163,861.9	176,658.9	12,796.9
<b>Үндсэн хөрөнгө</b>	3,079,854.6	3,220,474.5	140,619.9
<b>Нийт хөрөнгө</b>	<b>3,341,449.1</b>	<b>3,622,658.4</b>	<b>281,209.2</b>
<b>Өр төлбөр</b>	106.9		-
<b>Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/</b>	2,246,459.6	2,397,466.9	151,007.3
<b>Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү</b>	1,094,882.6	1,225,191.5	130,308.9
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>3,341,449.1</b>	<b>3,622,658.4</b>	<b>281,209.2</b>

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, бусад хангамжийн материал, өр төлбөр зэрэг дансуудад өөрчлөлт гарсан байна. Үүнд:

Мөнгөн хөрөнгө 127,649.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь өмнөх оны төсвийн үлдэгдэл мөн санхүүжилт нэмэгдсэнтэй холбоотойгоор өссөн байна.

Бараа материал дансны үлдэгдэл 12,796.9 мянган төгрөгөөр өссөн нь хандиваар 2,973.2 мянган төгрөгийн бичиг хэргийн материал “Дэлхийн зөн” олон улсын байгууллагаас авсан, бусад хангамжийн материал дансанд 1,504.0 мянган төгрөгийг хандиваар 2023 оны төгсөгчид болон сурагчдын зөвлөл авснаас шалтгаалан өссөн байна.

Бараа материал данснаас 603,300.0 мянган төгрөгийн тусгай зориулалтын материал, 1,025.5 мянган төгрөгийн бичиг хэрэг, 3,100.0 мянган төгрөгийн аж ахуйн материал, бусад хангамжийн материал 6,151.7 мянган төгрөгийн бусад хангамжийн материалыг сургуулийн захирлын 2023 оны 12 дугаар сарын 27-ны А/54 тоот тушаалаар тус тус акталсан байна.

Хүүхдийн үдийн хоол, дотуур байрны хүнсний материал худалдан авахад 3 удаа тендер зарласан боловч тендерт оролцогч байхгүй тул Элбэг сээлс ХХК-тай гэрээ байгуулан шууд худалдан авалт хийсэн байна.

Үндсэн хөрөнгө данс 140,619.9 мянган төгрөгөөр өмнөх оноос өссөн нь, хандиваар 9,000.0 мянган төгрөгийн нэгдүгээр хоолны тогоо, 1997 оны төгсөгчдөөс 8,500.0 мянган төгрөгийн 50 инчийн зурагт, Д.Ганболдоос 2,000.0 мянган төгрөгийн хөлдөөгч 1 ш, 600.0 мянган төгрөгийн бойлуур, Төв аймгийн Засаг даргын Тамгын газраас 30,960.0 мянган төгрөгийн 30 ш зөөврийн компьютер, Аймгийн боловсролын газраас 1,500.0 мянган төгрөгийн физикийн хичээлийн иж бүрдэл, худалдан авах ажиллагаанаас хандиваар 53,610.0 мянган төгрөг, төсвийн хөрөнгөөр 56,320.8 мянган төгрөгийн хөрөнгө авсан. Орон нутгийн хөгжил сангаас 20,000.0 мянган төгрөгийн биеийн тамирын талбайг хөрөнгөд бүртгэсэн зэргээс шалтгаалан өссөн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,756,240.0 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 197,779.7 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоос 17,287.9 мянган төгрөг, нийт зарлагыг 1,971.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас зардлыг 8.1 мянган төгрөгөөр бууруулж, 1,971,299.5 мянган төгрөгөөр баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 1,786.700.0 мянган төгрөгөөр тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 12 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,786.700.0 мянган төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,786.700.0 мянган төгрөг буюу 103,1 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 16,487.4 мянган төгрөгөөр, үүнээс үндсэн цалинг 8,019.8 мянган төгрөгөөр, нэмэгдэл цалинг 1,586.9 мянган төгрөгөөр тус тус илүү зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Д/д	71802-Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80226 Байр ашиглалт	5,241.7	5,241.7	-	100%

/мянган төгрөгөөр/

2	80312 Сургалт семинар	2,386.8	2,300.0	86.8	96.3%
3	81605 Эрүүл мэндийг дэмжих	4,671.0	3,210.0	1,461.0	68.7%
4	81801 Үдийн цай хөтөлбөр	121,376.5	106,172.5	15,203.9	87.5%
5	81806 Дотуур байрны үйлчилгээ	71,870.2	61,247.2	10,622.9	85.2%
6	81816 Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	52,952.1	52,952.1	-	100%
7	81823 Багш ажилтны мэргэжил дээшлүүлэх	10,598.4	7,620.0	2,978.4	71.9%
8	81827 Бичиг үсгийн боловсролын хөтөлбөр	4,024.9	2,597.7	1,427.1	64.5%
9	81834 Боловсролын стандарт	1,412,190.2	1,282,947.8	129,242.3	90.8%
10	81835 Сургалтын хэвийн үйл ажиллагаа	269,833.4	233,507.7	36,325.6	86.5%
11	81844 Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн сургалт	10,786.2	10,254.1	532.1	95.06%
12	81848 Сурах бичгийн түрээс	6,368.1	6,368.1	-	100%
13	80111 Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	197,779.6	195,11.6	1,665.0	99.2%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Баянчандмань сумын Ерөнхий боловсролын сургууль нь нэмэлт санхүүжилтийн төсөв байхгүй.

### 3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 1 хөтөлбөрийн 13 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	/мянган төгрөгөөр/		
				Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	71802-80226	2023-12-31	Байр ашиглалтын үйлчилгээ	99.3%	4,275.4	4,246.8
2	71802-80312	2023-12-31	Сургалт семинар	96.7%	2,137.7	2,068.0
3	71802-81605	2023-12-31	Эрүүл мэндийг дэмжих	100%	4,275.4	4,275.4
4	71802-81801	2023-12-31	Үдийн цай хөтөлбөр	84.1%	99,115.8	83,958.5
5	71802-81806	2023-12-31	Дотуур байрны үйлчилгээ	95.0%	146,339.9	139,114.0

6	71802-81816	2023-12-31	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	100%	44,590.0	44,590.0
7	71802-81823	2023-12-31	Багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх	100%	9,619.7	9,619.7
8	71802-81827	2023-12-31	Бичиг үсгийн боловсрол олгох	19%	2,415.0	459.1
9	71802-81834	2023-12-31	Боловсролын стандарт	91.1%	1,181,734.7	1,077,351.7
10	71802-81835	2023-12-31	Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	91.9%	278,478.3	256,016.3
11	71802-81844	2023-12-31	Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн	100%	150.6	150.6
12	71802-81848	2023-12-31	Сурах бичгийн түрээс	78.5%	7,041.4	5,532.1
13	71802-80111	2023-12-31	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	99.2%	197,779.6	195,11.6

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төв аймгийн Баянчандмань сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2023 онд цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй байна. Худалдан авах ажиллагааны хүрээнд хоол хүнс 46,624.0 мянган төгрөгийн, бичиг хэрэг 303.5 мянган төгрөгийн, тээвэр шатахуун 3,668.0 мянган төгрөгийн тус тус төсвийн хөрөнгөөр худалдан авсан байна.

Хүүхдийн үдийн хоол хөтөлбөрийн хүнсний материалд 106,172.0 мянган төгрөгийн бараа материалыг Элбэг сээлс ХХК-тай гэрээ байгуулан шууд худалдан авалт хийсэн байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Баянчандмань сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг сайжруулах ажиллагчидтай холбоотой авлагыг барагдуулах, дансны үлдэгдлийг улирал, жилийн санхүүгийн эцэст баталгаажуулж байхтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Релаэнс секюритиз аудит” ХХК-ийн аудитор С.Дашдондог, аудитор Б.Мягмар нар гүйцэтгэж, хяналтыг “Релаэнс секюритиз аудит” ХХК-ийн захирал, аудитор Ж.Цэцэгмаа, Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Бямбацогт, аудитын менежер О.Амаржаргал, дарга, Тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Баянчандмань сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг 2024 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 07 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

#### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн, нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2,0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,720,000.0 мянган төгрөгөөс 2,0 хувиар буюу 34,400.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 27,520.0 мянган төгрөгөөр тооцлоо. Аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

#### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төв аймгийн Баянчандмань сумын Ерөнхий боловсролын сургууль нь тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хориглосон зардлууд гараагүй, төсвийн хөрөнгийг хэмнэлттэй зарцуулан ажилласан байна. Үүнд:

Цалин хөлс болон нэмэгдэл, урамшууллыг 148,607.7 мянган төгрөгөөр  
Ажил олгогчоос нийгмийн даатгалд олгох шимтгэл 19,820.1 мянган төгрөгөөр  
Норматив зардлыг 6,417.6 мянган төгрөгөөр  
Бараа үйлчилгээний бусад зардал 9,192.9 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн байна.

#### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Баянчандмань сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2023 онд шилэн дансанд 159 мэдээлэл оруулахаас 158 мэдээллийг хугацаанд нь мэдээлж, 1 мэдээлэл хугацаа хоцроон байршуулсан байна. Ирэх жилийн батлагдсан төсөв боловсролын ерөнхий газраас хугацаа хоцорч ирсэн байна.

##### Шийдвэрлэсэн нь:

Цаашид шилэн дансны хуулийг хэрэгжүүлэхдээ нэг ч мэдээлэл хоцруулахгүй байхыг анхааруулав.

##### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Баянчандмань сумын Ерөнхий боловсролын сургуулийн эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийгдсэн. Завсрын аудитын явцад асуудлын бүртгэлээр 1 зөвлөмж өгөгдсөн ба биелэлтийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянахад үр дүнтэй хэрэгжсэн тул аудитын тайланд тусгаагүй болно.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг 100 хувь биелүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		/мянган төгрөгөөр/ Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
<b>Акт</b>	-	-	-	-	
<b>Албан шаардлага</b>	2	211,570.1	2	211,570.1	-
<b>Зөвлөмж</b>	1	2,670.3	1	2,670.3	100%
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>214,240.4</b>	<b>3</b>	<b>214,240.4</b>	<b>-</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Баянчандмань сумын Ерөнхий боловсролын сургууль нь дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал байхгүй.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 33,570.4 мянган төгрөгийн 2 зөрчил илэрснээс 33,570.4 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

#### 5.1 Төлбөрийн акт

#### 5.2 Албан шаардлага

#### 5.3 Зөвлөмж

1. Зардлын данстай холбоотой асуудал

##### Илрүүлэлт:

Дотуур байрны хүүхдийн хоолны орц нормыг хэрэгжүүлэн ажиллаагүйн улмаас 2,700.1 мянган төгрөгийн зөрчил илэрсэн. Энэ нь Боловсрол, Шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын 2020 оны 12 дугаар сарын 02 өдрийн А\166, А\556, 222 тоот хамтарсан тушаалын заалт, санхүүгийн тайлангийн “Тохиолдсон байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### Өгсөн зөвлөмж:

Цаашид дээрх тушаалд дурдсан хоолны орц нормыг баримтлан ажиллахыг ахлах тогооч мөрдөж, нягтлан бодогч хяналт тавьж ажиллах.

## 2. Авлагын данстай холбоотой асуудал

### Илрүүлэлт:

Авлагыг барагдуулаагүй 30,870.3 мянган төгрөгийн авлагын тооцоо үүсгэсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2-т “хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага барагдуулаагүй”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасныг хангахгүй байна.

### Өгсөн зөвлөмж:

Цаашид өр, авлага үүсгэхгүй ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн	
							Тоо	Дүн	Тоо	Дүн			
Дүн													

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Батлагдсан жишиг нормыг дагаж мөрдөөгүй	1	2,700.1					1	2,700.1				
Авлагыг барагдуулаагүй	1	30,870.3					1	30,870.3				
Дүн	2	33,570.4					2	33,570.4				

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/					
			Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум  
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр  
Утас: +976 70272582, +976 70273204  
И –мэйл: [tuv@audit.gov.mn](mailto:tuv@audit.gov.mn), Вебсайт: [www.audit.mn](http://www.audit.mn)